



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар

А/771

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 “в”, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын ундны усны худаг, гэрэлтүүлгийн ажлыг байнгын ашиглалтанд оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Ц.Цогтбаяр

- Жаргалант сумын Засаг дарга

И.Гантогтох

- Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч

Н.Цацралцэцэг

- Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч

У.Пүрэвдорж

- Ховд "Цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ий Ерөнхий инженер

Б.Түмэнжаргал

- Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн

С.Батдорж

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга

Б.Төрболд

- "Тэмжин" ХХК-ний зургийн инженер

Нарийн бичгийн



дарга: Ц.Сувдаа

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Ховд аймгийн Жаргалант сумын ундны усны худаг, гэрэлтүүлгийн ажлыг ажлын даалгавар, зураг төсвийн дагуу, хуулийн хүрээнд байнгын ашиглалтанд авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

3. Дээрх ажлын захиалагчийн хяналтын зардлаас комиссын гишүүдийн шатахуун, унаа, хоол, томилолтын зардлыг санхүүжүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ